

2018 ОНД АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН

СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

2018 онд Улсын аварга шалгаруулах 27, аймагт хүлээн авч зохион байгуулж явуулсан улсын аварга 5, олон улс тив дэлхийн аварга шалгаруулах 8, хоёр улсын гэрээний дагуу 10 тэмцээнд тамирчдыг оролцуулсан.

2018 онд манай аймгийн баг тамирчид олон улс, улсын чанартай 36 тэмцээнд оролцож 26 тэмцээнээс нийт 175 медаль хүртэж олон улсын хэмжээний мастер 1, спортын мастер 2, спортын дэд мастер 3, 1-р зэргийн тамирчин 83 төрөн гарч Монгол улс болон Сэлэнгэ аймгийн нэрийг дуурсгаж олон улс Ази тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор эрх авсан таеквондо, чөлөөт бөх, шатар, жудо, боксын тамирчдад Засаг даргын захирамжаар сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн оролцуулснаар Сэлэнгэ аймгаас улсад шалгаран U-13, U-14, U-16 насны ангиллалд сагсан бөмбөгийн тамирчид ХБНГУ, Австри улсад болсон Олон улсын тэмцээн, Малайз улсад болсон Олон улсын хүүхдийн наадмуудад амжилттай оролцож алт мөнгө хүрэл медаль, Гонг хонг улсад болсон таеквондогийн олон улсын тэмцээнээс манай аймгаас оролцсон 8 тамирчин 5 мөнгө 2 хүрэл медаль, Солонгос улсад явагдсан Оюутны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан сумын 6 тамирчин оролцож 4 тамирчин дэлхийн аварга, 2 тамирчин мөнгөн медаль, Пауролифтингийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Сайхан сумын тамирчин Угтахбаяр оролцож дэлхийн аварга, Тайландын Вант улсын Чианг Май хотод болсон өсвөрийн шатарчдын 3 төрлөөр явагдсан Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 8 цом 12 медаль / Ч.Түвшинтулга 3 алт, Б.Содбаатар 2 мөнгө 1 хүрэл, Д.Цэлмүүн 1 мөнгө 2 хүрэл, Т.Номиндалай 1 мөнгө, 1 хүрэл / Жи ци зүгийн спортын ази тивийн аваргаар 1 алт 1 мөнгө, боксын тамирчид Англи улсад болсон олон улсын тэмцээнээс 1 алт 1 мөнгөн медаль, Цюү жүцүгийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс Ж.Мөнгөншагай алт, Б.Шинэтулга, Ж. Гансүрэн, М.Төгсжаргал нар мөнгө, Б.Төгөлдөр хүрэл, Цюү жүцүгийн Азийн хүүхдийн наадамд Ө.Тэргэл, Б.Төгөлдөр, М.Төгсжаргал, З.Содбилэг, Б.Мөнхэрдэнэ, Ж.Мөнгөншагай, Энхбилэг нар алт, Цюү жүцүгийн өсвөрийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Б.Шинэтулга мөнгө, З.Содбилэг Б.Мөнхэрдэнэ нар хүрэл медаль хүртсэн сайхан амжилтуудыг үзүүлсэн.

Жицүжүгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд сэлэнгэ аймгаас 20 тамирчин оролцож нийт 29 байгууллагаас 8 алт 4 мөнгө 2 хүрэл медаль хүртэн багийн дүнгээр 2-р байранд шалгарсан сайхан амжилтыг үзүүлсэн бол Самбо бөхийн насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 4 алт 1 мөнгө 1 хүрэл медаль хүртэн багийн дүнгээр 2-р байранд шалгарсан.

Багануур дүүрэгт болсон пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Сайхан сумын 6 тамирчин, Сүхбаатар сумын 2 тамирчин оролцож 3 алт 2 мөнгө 1 хүрэл медаль хүртсэн амжилтийг үзүүлэн шахалтийн төрлөөр 1 тамирчин Монгол улсын зэрэг цолын нэгдсэн ангиллын Спортын дэд мастерын болзол ханган биелүүлсэн.

Сэлэнгэ аймгийн таеквондогийн холбооны Мандал сумын "Хараагийн хөх чоно" клубын 8 тамирчин чансааг тэргүүлэн Конг Хонг улсад болсон "Азийн цом" олон улсын тэмцээнд оролцож 5 мөнгө 2 хүрэл медаль хүртэн Монгол улсынхаа нэрийг Ази тивийн дэвжээнд дуурсгасан амжилтыг үзүүллээ.

Боксын холбооны шинэчлэлт зорилтын дагуу тамирчдын бэлтгэл сургалтанд хяналт тавьж ажилласнаар 2018 онд Монголын боксын холбооноос тавьсан хүсэлтийн дагуу Ази тивийн хошой аварга Монголын боксын спортын ууган гавьяат тамирчин Хайдавын



Алтанхуягийн нэрэмжит залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг хүлээн авч тэмцээнд нийт 27 байгууллагын 200 гаруй тамирчид ур чадвараа гарган өрсөлдөж тэргүүн байр Алдар спорт хороо, дэд байранд 2 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж Улаан ирвэс клуб, гутгаар байр Эрдэнэт бокс клубууд удааллаа.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд тамирчдыг төлөөлж Сэлэнгэ аймгийн Улаан ирвэс боксын клубын тамирчин О.Есүгэн, шүүгчдийг төлөөлж Олон улсын Боксын холбооны 2 одтой шүүгч Мандахбаяр нар тангараг өргөлөө.

Сэлэнгэ аймагт хоккейн спортын холбоог байгуулан үйл ажиллагаа нь хэвийн явагдаж 2017,



2018 оны өсвөр үеийн бага насны **Улсын** аварга шалгаруулах тэмцээнийг Ерөө сумын Бугант тосгонд 2 дахь удаагаа хүлээн авч зохион байгуулан Дархан, Орхон, Улаанбаатар, Шарын гол, Налайх дүүрэг, Баянгол, Бугант тосгон зэрэг



багууд оролцсон тэмцээнээс Бугант тосгоны баг тамирчид өсвөрийн улсын аваргаас алтан медаль хүртэж Улсын аварга болсон байна.

Өсвөрийн шатарчдын Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Улсын их хурлын гишүүн Н.Оюундарийн нэрэмжит болгон амжилттай явагдаж тус тэмцээнд 17 сумын 20 гаруй клуб, сургуулийн 400 гаруй тамирчид 6 насны ангилалд өрсөлдөж өмнө байгаагүй олон тамирчдыг хамруулан оролцуулж нас тус бүрд шалгарсан болон Ө.Баточир дасгалжуулагчтай баг тамирчдыг улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулснаар 1 алт, 2 мөнгө, 3 хүрэл хүртэн багаараа 2-р байранд шалгаран цом мөнгөн медаль хүртэж сүүлийн жилд гараагүй амжилтыг үзүүлсэн нь сум бүрийн шатрын спортыг материаллаг баазтай болгосноор өрсөлдөөнтэй, оюуны спортоор олон хүүхэд хичээллэж байгаа харагдан Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гарган Тайланд улсад болсон өсвөрийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан тамирчдыг Аймгийн засаг дарга дэмжин оролцуулснаар Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 8 цом 12 медаль / Ч.Түвшинтулга 3 алт, Б.Содбаатар 2 мөнгө 1 хүрэл, Д.Цэлмүүн 1 мөнгө 2 хүрэл, Т.Номиндалай 1 мөнгө, 1 хүрэл/ хүртсэн сайхан амжилтыг үзүүлсэн байна.





Өсвөрийн улсын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнд манай аймгийн баг тамирчид шинэ холбооны чиглэл зорилтын дагуу ажиллан баг тамирчид нь Сэлэнгэ түмнийхээ итгэл найдварыг алдалгүй хүч чадал, авьяас билгээ дайчлан оролцож Г.Дагва, Г.Мягмарсүрэн дасгалжуулагчтай Сэлэнгэ аймгийн баг тамирчид 1 мөнгө 2 хүрэл медаль хүртэж 21 аймгаас багаараа Улсын аварга гэсэн эрхэм цолыг хүртсэн.

Жудо бөхийн холбоо нь олон сайхан арга хэмжээг аймаг орон нутагтаа хүүхэд залуучуудын дунд зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаа жудо бөхийн холбоонд хүсэлтээ гарган хамтран ажиллах чиглэл зорилт 2018 оны өсвөрийн улсын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнийг орон нутагтаа хүлээн авч хүн бүрийн сэтгэлд нийцсэн үзэл сурталын өндөр хэмжээнд зохион байгуулсан.



Энэ удаагийн тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Мандал сумын уугуул Олон Улсын хэмжээний мастер Гомбын



Баатарсүрэнгийн нэрэмжит болгон явуулж тэмцээнд нийт хөвгүүдийн 25, охидын 16 нийт 41 жинд 46 багийн 1160 гаруй тамирчид оролцож багийн дүнгээр эрэгтэй Алтан медаль – Женко, Мөнгөн медаль – Дархан, Хүрэл медаль –Ховд, Хүрэл медаль –Увс, Багийн дүн Эмэгтэй Алтан медаль – Улаанбаатар хотын Спорт сургууль, Мөнгөн медаль –Женко Хүрэл медаль –Ховд, Хүрэл медаль –Шинэбадрах дэвжээний тамирчид эзэлсэн байна.

. Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит чөлөөт бөхийн барилдааны өсвөр үеийнхний олон хотын тэмцээнийг энэ жил 41 дэх жилдээ явуулан тэмцээнд хил зэргэлдээ орших Буриад улсын 3 баг, Монгол улсын аймаг хотуудын/ Сэлэнгэ, Дархан, Орхон, Төв, Дорноговь,Өмнөговь, Сонгинохайрхан дүүрэг, Налайх, Багануур дүүрэг/ 27 байгууллагын 480 гаруй тамирчид ирж оролцсон. Сэлэнгэ аймгийн баг тамирчид 1 мөнгө ,1 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн

Тэмцээнийг чөлөөт бөхийн холбооны тэргүүн Аймгийн засаг дарга Ш.Оргил нээж цаашид чөлөөт бөхийг орон нутагт хөгжүүлэх зорилтын талаар ярьж чөлөөт бөхийн ордонтой болох асуудлыг дэвшүүлэн тавилаа. Тэмцээнийг Монголын чөлөөт бөхийн холбооны шүүгч нар зохион байгуулалтын өндөр түвшинд амжилттай явуулаа.



Даам спортын суурь бааз нь Баянгол сумын сургууль бөгөөд жил бүр уламжлан сургуулийнхаа нэрэмжит болгон аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг хүлээн авч

зохион байгуулан түрүүлсэн тамирчдаа шигшэн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулснаар 2018 онд 2 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлж Аймаг орон нутагтаа даамын спортыг хөгжүүлэх чиглэлээр Монголын даамын холбоонд тавьсан хүсэлтийн дагуу зэрэггүй даамчдын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Баянгол суманд хүлээн авч амжилттай зохион байгуулан олон даамчдын зэрэглэлийн чансааг ахиулан 8 аймаг Улаанбаатар хотын 5 дүүргийн 360 гаруй тамирчид оролцсон нь хөгжих боломжийг нээж өгсөн.

Таеквондогийн улсын аварга шалгаруулах өсвөр, залуучуудын тэмцээнд Мандал сум, Сайхан Сүхбаатар сумын баг тамирчид аймаг орон нутгаа төлөөлөн оролцож 2 алт, 4 мөнгө 7 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлэн улсад 2-р байранд шалгаран, пумзегийн төрлөөр багаараа 3-р байранд шалгарсан амжилтуудыг үзүүлсэн



Мөн БНСУлсын элчин сайдын яамны нэрэмжит “Ирээдүйн одод” таеквондогийн олон улсын 24 тамирчин оролцож 3 алт, 2 мөнгө, 4 хүрэл медаль хүртэн фунзегийн төрлөөр багаараа 3 тамирчин оролцож тэргүүлэн алтан медалийн эзэнээр тодорсон



сайхан амжилтуудыг үзүүлсэн.

Говьалтай аймагт болсон бага насны /12 хүртэл / Улсын аварга шалгаруулах тэмцээнд Сэлэнгэ аймгийн Мандал Сайхан сумын тамирчид оролцон 2 алт 3 мөнгө 1 хүрэл медаль хүртсэн амжилтуудыг үзүүлсэн байна.

Монголын Үндэсний Пара хөнгөн атлетикийн холбооны Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгууллаа. Тус тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг Даргын орлогч Б.Нарантуяа, Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэсийн дарга Энхбат, Сэлэнгэ аймгийн Биеийн тамир спортын газрын дарга Б.Баттулга, Монголын Үндэсний Паралимпийн холбооны ерөнхийлөгч Б.Батдорж, Монголын хөнгөн атлетикийн холбооны Улсын шүүгч Д.Сумъяа, Монголын Паралимпийн хорооны ажилтан Сүхбаатар Үндэсний Биеийн тамирын Дээд сургуулийн багш А.Мөнх-Эрдэнэ, Улсын шүүгч Д.Батсайхан, Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч Б.Энхбаатар, Дашдондог, Сэлэнгэ аймгийн Парахөнгөн атлетикийн холбооны салбарын тэргүүн Ц.Энхцэцэг, Сэлэнгэ аймгийн хараагүйчүүдийн холбооны тэргүүн Ж.Ганчимэг нар оролцож МҮОХ “ Алтан Од ” медалиар Алтанчимэг, БТСГ-ын “ Хүндэт тэмдэг ” –ээр Д.Элбэгзаяа, Д.Уранчимэг, БТСГ-ын “Тэргүүний ажилтан ” цол тэмдэгээр С.Батболд, БТСГ-ын “ Алтан Од” медаль Золзаяа, Засаг даргын “Жуух “ бичгээр Батчимэг нарыг шагнаж урамшууллаа. Тус тэмцээнд: Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон, Архангай, Төв, Говь алтай, Дархан-



Уул, Дорнод, Өвөрхангай, Булган, Өмнөговь, Сүхбаатар, аймгууд болон Улаанбаатар хотын Налайх, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нийт 250 гаруй тамирчид, шүүгчид,



дасгалжуулагчид, аймгуудын нийгмийн халамж үйлчилгээний хэлтэсийн удирдлагууд болон албаны хүмүүс оролцлоо. Тэмцээн нийтдээ 39 төрлөөр явагдаж манай аймгаас 26 тамирчин оролцон 4 алт 5 мөнгө 8 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр тэргүүн байранд Ховор-Эрдэнэ дасгалжуулагчтай Дархан-Уул аймаг, удаах байранд Ц.Энхцэцэг дасгалжуулагчтай Сэлэнгэ аймаг, гутгаар байранд Цэвэлмаа дасгалжуулагчтай Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн баг тамирчид удааллаа.

Монголын үндэсний спортын 6-р их наадамд спортын 10 төрлөөр оролцож үндэсний бөхийн баг тамирчид амжилттай оролцож хүрэл медаль, урианхай сурын харвааны тамирчид хүрэл медаль, Морин спортын холбооноос оролцуулсан жороо морины уралдаанд мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.

Сэлэнгэ аймгийн волейболын холбооны тавьсан хүсэлтийн дагуу Мандал сумын Арцат зусланд Мини волейболын 14 хүртэлх насны Улсын аварга шалгаруулах тэмцээнийг хүлээн авч зохион байгуулан тус арга хэмжээнд 245 багийн 1400 гаруй тамирчид оролцсон тамирчдын ур чадварыг харуулсан тэмцээн боллоо, Тус арга хэмжээнд Сэлэнгэ аймгаас Цагааннуур, Мандал, Орхон сумдын баг тамирчид оролцсноос Мандал сумын 12-14 насны баг 3-р байранд шалгарч хүрэл медалийн эзнээр тодорсон. Тэмцээнийг УИХурлын гишүүн Аймгийн волейболын холбооны тэргүүн Ж.Эрдэнэбат, Мандал сумын ЗДТГазар, Арцат зуслан, Монголын волейболын холбоо хамтран зохион байгуулсан.

Онцгой байдлын албаны 2018 оны мэргэжлийн чиглэлийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн ОБГазартай хамтран зохион байгууллаа. Тэмцээнд бүсээс шалгарсан шилдэг багууд / хойд бүс, өмнөд бүс, баруун бүс, зүүн бүс, үндэсний аврах бригад, НОБГазар, ОБЕГазар, ахмадууд/ сагсан бөмбөг, хөл бөмбөг, усан сэлэлтийн тэмцээнүүдээр шилдэг баг, аваргуудаа шалгаруулан авхаалж самбаа, ур чадвараа гарган өрсөлдлөө. Багийн нийлбэр дүнгээр хойд бүсийн баг тамирчид тэргүүлэн цомын эзнээр тодорсон.

2019 ОНД АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН

СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

2019 онд Аймгийн аварга шалгаруулах тэмцээн 21, Улсын аварга шалгаруулах 31, аймаг орон нутагт хүлээн авч зохион байгуулсан Улсын аварга шалгаруулах 8 тэмцээн /мини волейбол, хоккей, жудо, шатар, даам. Хөл бөмбөг, уулын дугуй, усан сэлэлт / олон улс тив дэлхийн аварга шалгаруулах 9, хоёр улсын гэрээний дагуу 8 тэмцээнд оролцуулан Сэлэнгэ аймгийнхаа иргэдэд байнга хүргэж үйлчиллээ.

Манай аймгийн баг тамирчид олон улс ,улсын чанартай 54 тэмцээнд оролцож 37 тэмцээнээс нийт 196 медаль хүртэж олон улсын хэмжээний мастер 1, спортын мастер 6, спортын дэд мастер 1 , 1-р зэргийн тамирчин 75 төрөн гарч Сэлэнгэ аймгийн хурц арслан Б.Орхонбаяр нь Тулгар төрийн 2228 жил, Их монгол улсын 813 жил, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадмаар улсад 5 даван шөвгөрч Монгол улсын начин цол хүртсэн, Жюүжицү бөхийн өсвөрийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Б.Шинэтулга, Г.Батцэцэг нар алтан медаль, С.Шинэхүү мөнгө, Г.Мөнхтуяа хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлж, чөлөөт бөхийн төрлөөр АНУ-ын Пенсилвани хотод болсон олон улсын тэмцээнээс чөлөөт бөхийн тамирчин Ц.Хулан хүрэл медаль, Жюүжицү бөхийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс тэмцээнээс 8 алт, 4 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж багаараа 2-р байр, боксын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж багаараа 3-р байр, Хүүхдийн спортын 6-р наадмын волейболын улсын бүсийн тэмцээнд эрэгтэй баг тэргүүн байр, эмэгтэй баг хоёрдугаар байр, сагсан бөмбөгийн улсын бүсийн тэмцээнд эрэгтэй баг тэргүүн байр, эмэгтэй баг хоёрдугаар байр, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнд эрэгтэй баг тамирчид тэргүүлэн хүүхдийн спортын наадамд оролцох эрхээ авч зуны нийт спортын 19 төрлөөр 209 тамирчин оролцуулахаар урьдчилсан мэдүүлэг хүргүүлсэн боловч 207 тамирчин шигшээ тэмцээнд оролцож төрөл тус бүрд 6 алт 10. мөнгө 12 хүрэл медаль хүртэж үндсэн төрлөөр багаараа 9-р байр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрлөөр 1 алт, 1 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж 12-р байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн.Таеквондогийн төрлөөр хүүхдийн спортын 3 наадамд дараалан тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн.



Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит чөлөөт бөхийн олон хотын нээлттэй тэмцээн монгол улсдаа 42 дахь жилдээ тасралтгүй зохиогдож байгаа цорын ганц тэмцээн юмаа, өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээний өмнө болж байгаатай холбоотой тамирчид, дасгалжуулагч нарийг сориж байгаа томоохон



тэмцээн болж байна. Манай тэмцээнд 36 байгууллагын 159 охид 7 жинд, 549 хөвгүүд 15 жинд нийт 708 тамирчин 22 жинд 88 багц медалийн төлөө 2 хоног авхаалж самбаа, хурд хүчээ сорин барилдлаа. Тэмцээний шагналын сан монгол улсдаа төдийгүй улсын аварга шалгаруулах тэмцээнтэй дүйцэхүүц шагналаар шагнан урамшуулсан.Тэмцээнийг чөлөөт бөхийн холбооны тэргүүн Аймгийн засаг дарга Ш.Оргил нээж цаашид чөлөөт бөхийг орон нутагт хөгжүүлэх зорилтын талаар ярьж чөлөөт бөхийн ордонтой болох асуудлыг дэвшүүлэн тавилаа. Тэмцээнийг Монголын чөлөөт бөхийн холбооны шүүгч нар зохион байгуулалтын өндөр түвшинд амжилттай явууллаа.

Багийн дүнгээр:

1-р байр Ё.Батдархан дасгалжуулагчтай “Дархан хасу” клуб 74 оноогоор 2-р байр Г.Нямбаяр дасгалжуулагчтай “ТСБТТСургууль” 53 оноогоор 3-р байр Л.Энхбаяр дасгалжуулагчтай “Төв” клуб 34 оноогоор байр эзэлж Сэлэнгэ аймгийн тамирчид 1 алт 1 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр Ш.Оргил даргатай Сэлэнгэ аймгийн монгол ардын намын хороо.

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргилын ивээл дор шатрын спортыг хүүхэд багачууд болон өсвөр үеийнхэнд түгээн дэлгэрүүлэх ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сэтгэн бодох ур чадварыг дээшлүүлэх, 2019 оны Монгол Улсын өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах, тив, дэлхийн аваргын тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцох тамирчдыг сонгож, эрх олгох, Хөдөө орон нутагт шатрын спортыг хөгжүүлэх зорилгоор ардын хувьсгалын өлгий, амуу буудайны эх нутагт өсвөрийн шатарчдын 2019 оны улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээний нэгдсэн дүн гарлаа. Тэмцээний хаалтын үйл ажиллагаанд



Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймгийн шатрын холбооны дэд тэргүүн Э.Оюунболд, Монголын шатрын холбооны Гүйцэтгэх



захирал, Доктор Ц.Цогбаяр, Монголын шатрын холбооны дэд ерөнхийлөгч, Спортын мастер, Дэлхийн шатрын холбооны дасгалжуулагч, доктор профессор М.Баасанжав, Сэлэнгэ аймгийн Биеийн тамир спортын газрын дарга У.Батмөнх, Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга П.Оюун, Сэлэнгэ аймаг Алтанбулаг сумын уугуул Олон улсын шатрын эмэгтэй Их мастер А.Энхтуул, Шатрын холбооны мастер, Олон улсын шүүгч, Тус тэмцээний ерөнхий шүүгч Ч.Мөнхбат, Монголын шатрын холбооны тэмцээн, сургалт хариуцсан менежер Д.Эрдэнэбат, Аймгийн шатрын холбооны нарийн бичгийн дарга, Олон улсын дасгалжуулагч, Спортын мастер Ө.Бат-Очир нарын албаны хүмүүс оролцлоо.

Багийн дүнгээр

1-р байр Хэнтий аймаг

2-р байр Дорнод баймаг

3-р байр Дархан –Уул аймгийн баг тамирчид удаалж Сэлэнгэ аймгаас оролцсон тамирчид алт мөнгө хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.



Сэлэнгэ аймагт хоккейн спортын холбоог байгуулан үйл ажиллагаа нь хэвийн явагдаж 2017, 2018 2019 оны өсвөр үеийн бага насны **Улсын** аварга шалгаруулах тэмцээнийг Ерөө сумын Бугант тосгонд 3 дахь удаагаа хүлээн авч зохион



байгуулан Дархан, Орхон, Улаанбаатар, Шарын гол, Налайх дүүрэг, Баянгол, Бугант тосгон зэрэг багууд оролцсон тэмцээнээс Бугант тосгоны баг тамирчид өсвөрийн улсын аваргаас алтан медаль хүртэж Улсын аварга болсон байна.

ОХУ-ын Буриад улсын гавъяат дасгалжуулагч Д.Эрдэнэбатын нэрэмжит жүдо бөхийн насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын жудо бөхийн холбоотой зөвшилцсөний дагуу Аймгийн ЗДТГазар дэмжин аймаг орон нутагтаа Жү-до бөхийн эрэгтэйчүүдийн 41, эмэгтэйчүүдийн 27, багийн 7 дах удаагийн тэмцээнд Ардын багш 2, Хөдөлмөрийн баатар 1, гавъяат дасгалжуулагч

3, гавъяат тамирчин 6, Олон улсын хэмжээний мастер 10 гаруй, Спортын мастер 22, хот хөдөөгийн 25 байгууллагын 260 гаруй тамирчдыг Олон улсын 10 гаруй шүүгч шүүн явууллаа.

Тэмцээний нээлтийн ажиллагаанд Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа, Ерөнхийлөгчийн тамгын газрын дэд дарга н.Гантөмөр, Монголын жү-до бөхийн холбооны гүйцэтгэх захирал М.Бөхбат нарын албаны хүмүүс оролцлоо.

Багийн тэмцээнд

1-р байр Сүлд спорт хороо/ ШШГЕГ /

2-р байр Хилчин спорт хороо / ХХЕГ /

3-р байр Эрч спорт хороо / ТЕГ /

3-р байр Женко клуб

Шилдэг Эмэгтэй тамирчин Л.Сосорбарам -52 кг / Баянхонгор /

Эрэгтэй тамирчин Э.Мөнхжаргал -90 кг / Сүлд спорт хороо /

Д.Эрдэнэбат багшийн гарын бэлэг, мөнгөн шагналаар

Ц.Цогтбаатар / Сүлд спорт хороо /

Б.Баасанжаргал / Хилчин спорт хороо / нар шалгарлаа.

21 аймгийн хөл бөмбөгийн Үндэсний цом-2019 насанд хүрэгчдийн тэмцээнийг Монголын хөл бөмбөгийн холбооноос тавьсан саналын дагуу Аймгийн засаг даргын дэмжлэгтэйгээр орон нутагтаа хүлээн авч тус тэмцээнд 18 аймгийн 200 гаруй тамирчид өрсөлдөж

Дээд шатны ангилалд 1-р шатны ангилалд

1-р байр Дархан-уул , Баян-өлгий

2-р байр Орхон Увс

3-р байр Сэлэнгэ аймаг Сүхбаатар аймгууд удаалж

үндэсний цом насанд хүрэгчдийн тэмцээнийг Жаргалсайхан дасгалжуулагчтай Дархан-уул аймгийн баг тамирчид 3 дахь удаагаа тэргүүлж Шилжин явах цомыг үүрд хадгаллаа.

Сагсан бөмбөг 21 аймгийн лигийн тэмцээний шувтаргын аваргын төлөө тоглолтыг тухайн гарсан багуудын аймгуудад хувиарласан тоглолтын дагуу Багануур –Сэлэнгэ аймгийн багуудын тоглолтын 2дахь ээлжийн тоглолтыг орон нутагтаа хүлээн авч зохион байгуулан Сэлэнгэ аймгийн баг 2-р байранд шалгаран амжилтыг үзүүллээ



Монголын хүүхдийн спортын VI-р их наадмын Төвийн бүсийн аварга шалгаруулах Волейбол"-ын тэмцээн Сэлэнгэ аймгийн Мандал суманд 2019 оны 04-р сарын 19-21 ны хооронд



амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнд Төв аймаг, Өмнөговь аймаг, Сэлэнгэ аймаг, Дархан-Уул аймаг, Дундговь аймаг, Зүүнхараа Ноён баг гэсэн нийт 6-н аймгийн эрэгтэй 6 баг, эмэгтэй 7 багийн 170 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Эрэгтэй:

- 1-р байр- Спортын мастер О.Наранбаатар дасгалжуулагчтай Г.Тэнгис ахлагчтай “Сэлэнгэ” аймаг
- 2-р байр- Спортын мастер Ж.Мөнхбаяр,Т.Батзаяа дасгалжуулагчтай Санжмятав ахлагчтай “Зүүнхараа ноён”
- 3-р байр- Спортын мастер Х.Рэнцэндорж дасгалжуулагчтай З.Ган-Эрдэнэ ахлагчтай “Өмнөговь” аймаг

Эмэгтэй:

- 1-р байр-Спортын мастер Д.Болор-Эрдэнэ, дэд мастер Д.Алтанзул дасгалжуулагчтай, Б.Отгонжаргал ахлагчтай. “Дундговь” аймаг
- 2-р байр Спортын мастер Х.Рэнцэндорж дасгалжуулагчтай М.Нандинцэцэг ахлагчтай “Өмнөговь” аймаг
- 3-р байр-Спортын мастер А.Амартүвшин дасгалжуулагчтай Б.Сарангэрэл



ахлагчтай “Сэлэнгэ” аймгийн баг тамирчид Хүүхдийн спортын шигшээ наадамд оролцохоор шалгарлаа.

Онцгой байдлын албаны Улсын аварга шалгаруулах спортын тэмцээнийг аймаг орон нутагт хүлээн авч тэмцээнийг Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Аврагч биеийн тамир, Техникийн спорт хороо, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, Онцгой байдлын газрын хамтран зохион байгуулж буй спортын 3 төрөлтийн тэмцээнд багийн нийлбэр дүнгээр Хойд бүс 1-р байр, нийслэлийн Онцгой байдлын газар 2-р байр, өмнөд бүсийн баг тамирчид 3-р байрыг эзэлж цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа. Тэмцээнд бүс бүрээс шалгарсан тамирчид шигшээ баг бүрдүүлэн 6 бүсийн 278 тамирчид оролцсон байна.Онцгой байдлын албаны улсын аварга шалгаруулах 2018 оны спортын тэмцээний нээлтийн арга хэмжээнд бие бялдрын ерөнхий хөгжлийн 224 тоот дасгалыг Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 60 албан хаагч амжилттай хийж гүйцэтгэлээ.

ОХУ-ын Буриад улсын Гавъяат дасгалжуулагч, Алтангадас одонт, ОУХМастер Л.Зандангийн нэрэмжит Самбо бөхийн Өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Анх удаагаа хөдөө орон нутагт аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж, 17 аймгийн 40 байгууллагын 880 тамирчин 3 насны ангилалд нийт 38 жинд өрсөлдлөө. Тус тэмцээний нээлтийн ажиллагаанд Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил, МУЗГ-ын Хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-ын Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн С. Эрдэнэтуяа, Сэлэнгэ аймгийн БТСГ-ын дарга У.Батмөнх, Монголын самбо бөхийн холбооны ерөнхийлөгч Н.Гэрэл, УБЭҮ-ийн Хангарьд спорт ордоны орлогч дарга МУГТ Д.Нармандах нарын албаны хүмүүс оролцлоо.

Охидын багийн дүнгээр: Тэргүүн байр Женко групп, Дэд Шинэ бадрах дэвжээ,Гутгаар Хөвсгөл аймаг, Хөвгүүдийн багаас Тэргүүн байр Женко групп, Дэд Дархан-уул аймаг

Гутгаар Сүхбаатар аймаг

Самбо бөхийн түүхэнд хамгийн олон тамирчин оролцсоноороо онцлог болж “Дашваанжил” ХХК тус тэмцээнийг ивээн тэтгэн оролцлоо.



Мини волейболын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2 дахь жилдээ Мандал сумын Арцат зуслантай хамтран Монголын волейболын холбоо, Мандал сумын ЗДТГ, аймгийн волейболын холбоотой хамтран зохион байгууллаа. Тэмцээн 12 хүртэл, 13-14 насны ангиллаар зохион байгуулагдаж энэ удаагийн тэмцээнд 14 аймаг, 6 дүүрэг, байгууллагуудын 980 гаруй тамирчид оролцож ур чадвар авьяасаа уралдуулан өрсөлдөж Мандал сумын Мөнхбаяр дасгалжуулагчтай баг насны тамирчид хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн байна.

Биеийн тамир спортын тэргүүний ажилтан, дугуйн спортын мастер, ОХУ-ын Буриад улсын гавьяат ажилтан Биеийн тамир спортын газрын дарга асан Д.Эрдэнэбатын нэрэмжит Уулын дугуйн улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын дугуйн холбооноос тавьсан хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын тамгын газар хамтран хүлээн авч зохион байгуулсан. Тэмцээний нээлтийн ажиллагаанд аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэсийн дарга Д.Энхбат, Монголын дугуйн холбооны нарийн бичгийн дарга, ОХУ-ын Буриад улсын Петропавлик хотын биеийн тамир спортын газрын төлөөлөгчид А.М. Цаганов, А.А.Дагдунов, Жаргалович зэрэг албаны хүмүүс оролцсон байна. Тэмцээнд 13 аймгийн 80 гаруй дугуйчид 3 насны ангиллаар оролцож хурд хүч, тэсвэр тэвчээр гаргаж өрсөлдсөн. Тэмцээний багийн дүнгээр Төв аймаг, Сүхбаатар аймаг, спортын төв сургуулийн багууд эхний байруудад шалгарсан.

Сэлэнгэ аймаг спортыг дэмжигч аймаг болох уриа чиглэлийн дагуу Сайхан суманд Rew паурлифтингийн насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд 9 аймгийн 59 тамирчид / үүнээс эмэгтэй 19/ хүч чадал, тэсвэр тэвчээрээ харуулан өрсөлдөж Сэлэнгэ аймгийн тамирчин Угтахбаяр шахалтын төрлөөр монгол улсын рекордыг шинэчлэн тогтоосон сайхан амжилтыг үзүүлсэн.

Сэлэнгэ аймагт атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан усанд сэлэлтээр олон жил хичээллэсэн ахмад тамирчдыг идэвхитэй оролцуулах, бие бялдарыг чийрэгжүүлэх, усан спортыг аймаг орон нутагт сурталчилах, тамирчдын авъяас чадварыг хөгжүүлэх зорилготойгоор анх удаа мастерсийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ аймагт амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд Хангарьд, Баянгол дүүрэг, Виста, Баянзүрх дүүрэг, ОБЕГ, Орчлон, Дархан СПА, Сэлэм загас, 33-р сургууль, Тэмүүлэл, Jarden, АПУ трейд, болон Сэлэнгэ аймгийн ОБГ, Усан спорт



сургалтын төвийн нийт 40 гаруй тамирчид 25-29 нас, 30-34 нас, 35-39 нас, 40-44 нас, 45-49 насны ангилалд өврөөр даллах сэлэлт 50м, араар даллах сэлэлт 50м, мэлхий сэлэлт 50м, далайн гахай сэлэлт 50м зайд хурд хүчээ сорин өрсөлдлөө. Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ө.Сувдаа, Аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Монголын усан спортын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Х.Энхмандах, Биеийн тамир спортын газрын ахлах дасгалжуулагч Д.Энхбат, Усан спорт сургалтын төвийн эрхлэгч Ц.Уртнасан, Онцгой байдлын газрын дарга Г.Баатар нар тус тэмцээнийг нээлээ.



Энэ удаагийн тэмцээнд Усан спорт сургалтын төвөөс оролцсон А.Отгонцэцэг, Биеийн тамир спортын газрын ажилтан Т.Энхтуул нар анх удаа оролцон хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх тэднийг спортод дур сонирхолтой болгож татан оролцуулах чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран ажиллаж насанд хүрэгчдийн парахөнгөн атлетикийн тэмцээнд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулан хамтарсан бэлтгэл цугларалтанд оролцуулснаар уг тэмцээнээс 6 алт 10 мөнгө 2 хүрэл медаль хүртэн багаараа Улсын аварга гэсэн эрхэм цолыг хүртсэн амжилтыг гаргасан.